



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.07.28

Нэг: Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр: Танилцуулга

Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 82.1%-тай байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
75	55	3	7	4	-	1	5	92.22%

Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 онд эхний хасаг жилийн байдлаар 75 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 55 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 3 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 7 арга хэмжээ, 50%-ийн биелэлттэй 4 арга хэмжээ, 0 %-ийн биелэлттэй 1 арга хэмжээ, хугацаа болоогүй 5 арга хэмжээ, хэрэгжилтийг дунджаар авч үзвэл 92.22%-тай байна.

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
119	99	14	6	-	87.6%

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
34	21	9	4	-	70%

2.4. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
98	76	21	1	-	78.4%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Хэрэгжилтийн байдал:

1) Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны үйл ажиллагааг газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 82.1%-тай байна.

2) 2025 оны 06 дугаар сарын 25 ны өдөр Сайдын 2023 оны 231 дүгээр тогтоолоор батлагдсан тушаалын 3 дугаар хавсралтын 3.2 дахь заалтад заасны дагуу энэ оны 06 дугаар сарын 15-наас хойших биелэлтийг тайлагнасан тул үнэлгээг хангалтгүй гэж үзлээ. Уг арга хэмжээг 2025 оны 1 дүгээр улиралд хийж дуусахаар төлөвлөсөн байна.

3) ТЗУГ нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 75 арга хэмжээний хэрэгжилт 92.22 %-тай байна. Үүнээс 82.85 % нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 17.14% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй, хугацаа болоогүй 5 арга хэмжээ байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

ТЗУГ-ын 2025 оны үйл ажиллагааны эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

4.1 Сайд, Төрийн нарийн бичгийн даргын 2023, 2024 онуудад тушаалаар өгсөн үүргийг он дамжиж, цаг хугацааны хувьд удаашралтай байгаа арга хэмжээг эрчимжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол авч, тушаалын хэрэгжилтийг хариуцсан газар, нэгжид сануулах, анхааруулах, ажлыг идэвхжүүлэх, мөн биелэлт хэрэгжсэн ч хяналтаас хасагдаагүй байгаа зэрэг арга хэмжээнүүдийг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газартай зөвшилцөж, хяналтаас хасуулах;

4.2. Шинээр батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”-аар Бодлогын баримт бичиг, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалд өөрчлөлт орж, тайлагнах хугацаа, биелэлтийн явцын үр дүнгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх тул Дээд газрын үүрэг даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр чанартай, үнэн зөв, бүрэн тайлагнах;



4.3. Мөн Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж, Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан, Гадаад, дотоод томилолтоор ажилласан тохиолдолд холбогдох журамд заасан хугацаанд хийсэн ажлын тайланг гаргаж, хэвшихийг тус тус зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР